

**7. Тухайн үнэт цаасыг худалдан авснаар хөрөнгө оруулагчид учирч болох эрсдэл, эрсдлийн шинжилгээ:**

*Хөх ган энгийн хувьцааг худалдаж авснаар хөрөнгө оруулагчид дараах зүйлүүд дээр анхаарч үзнэ үү.*

*Доор дурдсан эрсдлийн хүчин зүйлүүдээс хамааран компани төлөвлөсөн үр дүндээ хүрэхгүй байх магадлалтай. Эдгээрт:*

- i. Монгол улсын эдийн засаг, улс төрийн тогтворгүй байдал*
- ii. Үйл ажиллагааны эрсдэл*
- iii. Хууль эрх зүйн орчны өөрчлөлтүүд*
- iv. Зах зээлийн эрсдэл*
- v. Бусад эрсдэл*

*Зах зээлийн нөхцөлд бизнесийн орчны өөрчлөлтгүй хувьсамтгай байдал макро болон микро эдийн засгийн нөлөөлөлд аж ахуйн үйл ажиллагаагаа буруу тооцоолох, мөн инфляци эрсдэл, татварын эрсдэл, бүтээгдэхүүний үнэ ханшын бууралт гэх учирч болзошгүй эрсдэлийг үнэлж тооцох шаардлагатай.*

*Тус компанийн аж ахуйн үйл ажиллагаа явуулж байх тохиолдолд дараахи төрлийн эрсдэл учирч болох магадлалтай.*

*Үүнд:*

- Түли шатахууны үнийн өсөлт нь үйлдвэрийн үйл ажиллагааны зардлыг өсгөх магадлалтай.*
- Техник тоног төхөөрөмжийн эвдрэл*
- Компанийн зүгээс хүлээж болох гол эрсдэл нь түүхий эд ханшийн өсөлт*
- Үйлдвэрлэлийн технологийн горимыг чанд мөрдөн ажиллахтай холбогдон үүснэ.*

*Эдгээр эрсдлүүдийг багасгах зорилгоор доорхи үйл ажиллагааг авч явуулана.*

*Компанийн гол түүхий эд болох төмрийн хүдрийн баяжмалыг “Бэрэн групп” ХХК-аас авах ба түүхий эд худалдан авах гэрээг урьдчилсан байдлаар 2 жилийн хугацаатай байгуулсан билээ. “Бэрэн групп” ХХК-аас төмрийн хүдрийн баяжмал худалдан авахаар гэрээ байгуулснаар түүхий эдийн нөөцийн хомсдолд орох эрсдлийг багасгаж үйлдвэрийн үйл ажиллагаа олон жил тогтвортой жигд ажиллах бүрэн боломжтой болж байна.*

*/Бусад эрсдэл /давагдашгүй хүчин зүйлсийн эрсдэл: Байгалийн гэнэтийн үзэгдлүүд зэрэг хүчин зүйлс нь компанийн эзэмшиж буй үл хөдлөх хөрөнгө, тоног төхөөрөмжид гэмтэл, бэртэл, эрсдэл учруулах боломжтой ба үүнээс гарах эрсдэл, засвар зэрэгт зарцуулсан хөрөнгө нь компанийн санхүүгийн үзүүлэлтэнд муугаар нөлөөлөх талтай.*